

**ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ
АНХДАГЧ ХУУЛИЙН ТӨСЛИЙГ ДАГАЛДАН НЭМЭЛТ,
ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ХУУЛИЙН ТӨСЛҮҮД¹**

¹ 2 дахь хувилбар

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

АВТО ЗАМЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Авто замын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг тус бүрийг нэмсүгэй:

1/6 дугаар зүйлийн 6.5 дахь хэсэг:

“6.5.Авто замын салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/8 дугаар зүйлийн 8.7 дахь хэсэг:

“8.7.Энэ хуулийн 8.4-т заасан Авто замын норм, нормативын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн хүрээнд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ хамаарахгүй.”

3/8 дугаар зүйлийн 8.8 дахь хэсэг:

“8.8.Авто замын салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн норм, нормативын сангийн удирдлагыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.”

2 дугаар зүйл.Авто замын тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.21 дэх заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“4.1.21."магадалшгүй ажил" гэж Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн 29.4.3 дахь заалтын тайлбарт заасныг;”

3 дугаар зүйл.Авто замын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.8 дахь хэсгийн “магадлашгүй” гэснийг “магадалшгүй” гэж, мөн зүйлийн 20.9, 20.10 дахь хэсэг тус бүрийн “Магадлашгүй” гэснийг “Магадалшгүй” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны ... дугаар
сарын ..-ний өдөр

Улаанбаатар хот

БАРИЛГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Барилгын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг:

“2.4.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийг төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон хөрөнгийн удирдлага, ашиглалт, үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/5 дугаар зүйлийн 5.11 дэх хэсэг:

“5.11.Энэ хуулийн 5.7-д заасан барилга байгууламжийн норм, нормативын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн хүрээнд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ хамаарахгүй.”

3/5 дугаар зүйлийн 5.12 дахь хэсэг:

“5.12.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийн норм, нормативын сангийн удирдлагыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.”

4/24 дүгээр зүйлийн 24.1.5 дахь заалт:

“24.1.5.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн 5.1.5-д заасан хариуцлагатай байх.”

5/27 дугаар зүйлийн 27.3.4. дэх заалт:

“27.3.4.Төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх барилга байгууламжийн хувьд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн шаардлагыг хангаагүй, уг хуулийг зөрчсөн тохиолдолд.”

6/37 дугаар зүйлийн 37.1.21 дэх заалт:

“37.1.21.төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн хувьд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан захиалагчийн чиг үүргийг хэрэгжүүлэх.”

7/38 дугаар зүйлийн 38.1.11 дэх заалт:

“38.1.11.төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн хувьд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан зураг төсөл зохиогчийн чиг үүргийг хэрэгжүүлэх.”

8/40 дүгээр зүйлийн 40.1.25 дахь заалт:

“40.1.25.төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн хувьд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль болон төслийн хөрөнгө оруулалтын гэрээнд заасан гүйцэтгэгчийн үүргийг хэрэгжүүлэх.”

9/48 дугаар зүйлийн 48.9 дэх хэсэг:

“48.9.Тухайн жилийн төсвийн тухай хуулиар тухайн онд багтаан дуусахаар батлагдсан барилга байгууламжид ашиглалтад оруулах комисс ажиллах бөгөөд ашиглалтад оруулах дүгнэлт гаргах бол уг дүгнэлтийг тухайн жилийн 12 дугаар сарын 20-ны өдрийн дотор зохих ёсоор баталгаажуулан гаргасан байна.”

10/49 дүгээр зүйлийн 49.6 дахь хэсэг:

“49.6.Энэ хуулийн 49.1-д заасны дагуу төсвийн хөрөнгө оруулалтаар баригдаж, ашиглалтын гэрчилгээ олгосон барилга байгууламжид ашиглалтын тэмдэглэгээг тавьж, актаар баталгаажуулна.”

2 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 40 дүгээр зүйлийн 40.1.15 дахь заалтын “санд” гэсний дараа “, төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн хувьд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасны дагуу” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Барилгын тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.2.1, 25.2.2 дахь заалт тус бүрийн “өртгийн төсөвт” гэснийг “төсөвт өртөгт” гэж, 25.2.5 дахь заалтын “төсөв, нэгдсэн төсөв” гэснийг “зураг төсөл, инженерийн тооцоо, төсөвт өртөгт” гэж тус тус өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Барилгын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 болон 24.5 дахь хэсэг тус бүр, 33 дугаар зүйлийн 33.1.10 дахь заалтыг тус тус хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧЛИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчлийн тухай хуулийн Арван нэгдүгээр бүлэгт доор дурдсан агуулгатай 11.36 дугаар зүйл нэмсүгэй:

“11.36 дугаар зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль, журам зөрчих

1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль, холбогдох журамд заасан мэдээлэл, тайлан, дүгнэлтийг мэдээлээгүй, цахим системээр илгээгээгүй, цахим системд мэдээлэл оруулах, бүртгэх, баталгаажуулах, илгээхтэй холбоотой үүргээ зохих ёсоор биелүүлээгүй бол хүнийг нэг мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг таван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөлд хийсэн зураг төсөл, техник, эдийн засгийн үндэслэл, магадлал, холбогдох бусад шинжилгээ, судалгаа нь Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль, холбогдох хууль, журам, дүрэм, норм, нормативын баримт бичиг, стандартыг зөрчсөн, эсхүл шаардлагад нийцээгүй бол хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

3.Төсвийн хөрөнгө оруулалтын төсөл хэрэгжүүлэх талаар тогтоосон тусгай журмыг зөрчсөн бол учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг арван мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

4.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төсөлд хөндлөнгийн хяналт, захиалагчийн техникийн болон зохиогчийн хяналт хэрэгжүүлэгч нь холбогдох хуульд заасан хяналтын чиг үүргээ бүрэн, зохих ёсоор биелүүлээгүй бол учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.

5.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх барилга байгууламжийн төслийн гүйцэтгэгч нь:

5.1.төслийг төлөвлөсөн хугацаанд, үр дүнтэй хэрэгжүүлээгүй;

5.2.санхүүжилтийг зориулалтын дагуу зарцуулаагүй;

5.3.гэнэтийн болон давагдашгүй хүчин зүйл, гамшгийн эрсдэлээс урьдчилан сэргийлэх, хамгаалах арга хэмжээний төлөвлөгөө боловсруулж ажиллаагүй;

5.4.зүгшрүүлэх, тохируулах болон чанарын баталгаат хугацаанд илэрсэн ашиглагчийн буруутай үйл ажиллагаанаас үл хамаарах зөрчил, гэмтэл, дутагдлыг өөрийн хөрөнгөөр засварлаагүй бол учирсан хохирол, нөхөн төлбөрийг гаргуулж, хүнийг хорин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр, хуулийн этгээдийг хоёр зуун мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгоно.”

2 дугаар зүйл.Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЗӨРЧИЛ ШАЛГАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 6.67 дахь заалт нэмсүгэй:

“6.67.Санхүүгийн хяналт шалгалтын улсын байцаагч Зөрчлийн тухай хуулийн 11.36 дугаар зүйлийн 1, 3, 5 дахь хэсэгт заасан зөрчил.”

2 дугаар зүйл.Зөрчил шалган шийдвэрлэх тухай хуулийн 1.8 дугаар зүйлийн 6.38 дахь заалтын “11.2” гэсний дараа “дугаар зүйл, 11.36 дугаар зүйлийн 2, 3, 4 дэх хэсэг,” гэж, 6.40 дэх заалтын “11.2” гэсний дараа “дугаар зүйл, 11.36 дугаар зүйлийн 2 дахь хэсэг,” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

МОНГОЛ УЛСЫН ЗАСАГ ЗАХИРГАА, НУТАГ ДЭВСГЭРИЙН НЭГЖ, ТҮҮНИЙ УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 2.4 дэх хэсэг нэмсүгэй:

“2.4. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр орон нутагт төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон хөрөнгийн удирдлага, ашиглалт, үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Монгол Улсын засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5 дахь хэсгийн “Төсвийн тухай хууль” гэсний дараа “, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ӨРИЙН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Өрийн удирдлагын тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг:

“3.6.Гадаад зээллэгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээний төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/5 дугаар зүйлийн 5.1.6 дахь заалт:

“5.1.6.хувийн хэвшил бие даан санхүүжүүлж, хэрэгжүүлэх боломжтой төслийг өр үүсгэн санхүүжүүлэхгүй байх.”

3/12 дугаар зүйлийн 12.4 дэх хэсэг:

“12.4.Энэ хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан шаардлагыг хангаагүй, зориулалтад хамаарахгүй төслийг гадаад зээлийн эх үүсвэрээр өр үүсгэн санхүүжүүлэхгүй.”

4/18 дугаар зүйлийн 18.5.9 дэх заалт:

“18.5.9.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан холбогдох шаардлагыг хангасан байх.”

5/24 дүгээр зүйлийн 24.6 дахь хэсэг:

“24.6.Олон улсын гэрээ, хэлэлцээр, хууль тогтоомжид өөрөөр заагаагүй бол гадаад зээллэгийн хөрөнгөөр санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэдэх нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн бүтцээр дамжуулан хэрэгжүүлнэ.”

2 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төсвийн тухай хууль,” гэсний дараа “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл.Өрийн удирдлагын тухай хуулийн 24 дүгээр зүйлийн 24.4 дэх хэсгийн “үнэлэх журмыг санхүү, төсвийн асуудал эрхэлсэн Засгийн газрын гишүүн баталж, мөрдүүлнэ” гэснийг “үнэлэхтэй холбоотой харилцааг Төсвийн тухай хуулийн 11.1.24-т заасан журмаар зохицуулна.” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨМӨР ЗАМЫН ТЭЭВРИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төмөр замын тээврийн тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг тус бүрийг нэмсүгэй:

1/5 дугаар зүйлийн 5.2 дахь хэсэг:

“5.2.Төмөр замын салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/13 дугаар зүйлийн 13.4 дэх хэсэг:

“13.4.Энэ хуулийн 13.2-т заасан сангийн эх үүсвэрийг бүрдүүлэхэд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн хүрээнд улс, орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаад, зээл тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ хамаарахгүй.”

3/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:

13.5.Төмөр замын салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төслийн норм, нормативын сангийн удирдлагыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.”

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 2 дугаар зүйлд доор дурдсан агуулгатай 4 дэх хэсгийг нэмсүгэй:

“4. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон төрийн болон орон нутгийн өмчид хамаарах энэ хуульд зааснаас бусад хөрөнгийн бүртгэл, ашиглалт, түүний үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2 дугаар зүйл. Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 2 дахь хэсгийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

“2. Төсвийн тухай хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан эх үүсвэрээр болсон бий болсон хөрөнгө /дуусаагүй хөрөнгө оруулалт/ нь төрийн болон орон нутгийн өмч байна.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН БОЛОН ОРОН НУТГИЙН ӨМЧИЙН ХӨРӨНГӨӨР БАРАА, АЖИЛ, ҮЙЛЧИЛГЭЭ ХУДАЛДАН АВАХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг тус бүрийг нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.4 дэх хэсэг:

“2.4.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн худалдан авах ажиллагааг энэ хуулиар, төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах болон хөрөнгийн удирдлага, ашиглалт, үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/14 дүгээр зүйлийн 14.9 дэх хэсэг:

“14.9.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан төслийн гүйцэтгэгчийн үнэлгээгээр сайн гүйцэтгэлтэй буюу “ногоон” жагсаалтад багтсан хуулийн этгээдийн тендерт энэ хуульд заасан тендерийн баталгаа шаардахгүй.”

3/17 дугаар зүйлийн 17.7 дахь хэсэг:

“17.7.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн 48 дугаар зүйлд заасан төслийн гүйцэтгэгчийн үнэлгээнд тулгуурлан тендерт оролцогчийн техникийн чадавх, туршлагыг харгалзан үнэлнэ.”

4/17 дугаар зүйлийн 17.8 дахь хэсэг:

“17.8.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн 48.5-д заасны дагуу “улаан” жагсаалтад багтсан, төрийн худалдан авах ажиллагаанд оролцох эрх нь хязгаарлагдсан хуулийн этгээдийг төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр санхүүжүүлэх төслийн гүйцэтгэгчийн тендер шалгаруулалтад оролцуулахгүй.”

5/39 дүгээр зүйлийн 39.6 дахь хэсэг:

“39.6.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх төслийн гэрээнд энэ хуулийн 39.3-т зааснаас гадна Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль, холбогдох хууль, журамд заасан нөхцөлийг тусгана.”

2 дугаар зүйл.Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсэгт “Монгол

Улсын Үндсэн хууль,” гэсний дараа “Төсвийн тухай хууль, Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль,” гэж, 3 дугаар зүйлийн 3.1 дэх хэсэгт “орон нутгийн төсөв” гэсний дараа “, орон нутгийн хөгжлийн сан” гэж, 39 дүгээр зүйлийн 39.5 дахь хэсгийн “Иргэний хуулиар” гэсний дараа “, төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хувьд Иргэний хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨРИЙН ХЭМНЭЛТИЙН ТУХАЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төсвийн тухай хууль,” гэсний дараа “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль,” гэж нэмсүгэй:

2 дугаар зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн дараах хэсэг тус бүрийг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай.

1/13 дугаар зүйлийн 13.1 дэх хэсэг:

“13.1.Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, санхүүжилтийн асуудлыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.”

2/13 дугаар зүйлийн 13.5 дахь хэсэг:

“13.5.Орон нутгийн хөгжлийн сангийн хөрөнгийн эх үүсвэрээр санхүүжүүлэх төслийн төрөл, ангилал, зориулалт, төлөвлөлт, санхүүжилттэй холбогдсон харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.”

3 дугаар зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.1 дэх хэсгийн “шинээр барихыг хориглоно” гэснийг “шинээр барих тохиолдолд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.” гэж өөрчилсүгэй.

4 дүгээр зүйл.Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 7 дугаар зүйлийн 7.2 дахь хэсэг, 13 дугаар зүйлийн 13.2, 13.4, 13.6 дахь хэсэг тус бүрийг хүчингүй болсонд тооцсугай.

5 дугаар зүйл.Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Төсвийн тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг, заалт нэмсүгэй:

1/3 дугаар зүйлийн 3.6 дахь хэсэг:

“3.6.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын энэ хуульд зааснаас бусад төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт, хөрөнгийн удирдлага, ашиглалттай холбоотой харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/4 дүгээр зүйлийн 4.1.59 дэх заалт:

“4.1.59.“төсвийн хөрөнгө оруулалтын төсөл” гэж Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн 4.1.25-д заасныг;”

3/4 дүгээр зүйлийн 4.1.60 дахь заалт:

“4.1.60.“төсвийн хөрөнгө оруулалтын удирдлага” гэж Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн 4.1.26-д заасныг.”

4/11 дүгээр зүйлийн 11.1.24 дэх заалт:

“11.1.24.Засгийн газрын гадаад зээл, тусламжийн үйл ажиллагааны удирдлага, зохицуулалтын нэгдсэн журмыг батлах.”

5/12 дугаар зүйлийн 12.2.4 дэх заалт:

“12.2.4.төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, бэлтгэл ажиллагааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар хэрэгжүүлэх, төсвийн бүх шатны захирагч болон холбогдох бусад этгээдийг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах.”

6/25¹ дугаар зүйл:

“25¹ дугаар зүйл.Гадаадын тусламжийн удирдлага, зохицуулалт

25¹.1.Хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагаас олгох гадаадын тусламжийн санхүүжилт, хөрөнгийн эх үүсвэрийг оновчтой төлөвлөж, уг хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний хэрэгжилт, хяналт, хөрөнгийн бүртгэл,

тайлагналтыг нэгдсэн удирдлага, зохицуулалтаар хангах замаар тусламжийн хөрөнгийг зориулалтын дагуу үр дүнтэй, ил тод, хариуцлагатай зарцуулна.

25^{1.2}. Гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээ нь энэ хуульд заасан шаардлагад нийцсэн, холбогдох аргачлалын шалгуур үзүүлэлтээр үнэлгээ өгч эрэмбэлсэн, хөгжлийн түнш орон, олон улсын байгууллагатай байгуулсан гэрээний үндсэн зориулалтад нийцсэн, нийгмийн ач холбогдол бүхий төсөл байна.

25^{1.3}. Төсвийн ерөнхийлөн захирагч, төсөл хэрэгжүүлэгч байгууллага нь гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжиж байгаа төсөл, арга хэмжээг төлөвлөсөн хугацаанд үр дүнтэй хэрэгжүүлж, төсөв, хөрөнгийг зохистой, үр ашигтай зарцуулах бөгөөд төсөл, арга хэмжээний үйл ажиллагаа, ажил, үйлчилгээний гүйцэтгэлд хяналт тавьж, холбогдох хууль тогтоомжийн хэрэгжилтийг хангаж ажиллах үүрэгтэй.

25^{1.4}. Гадаадын тусламжийн хөрөнгөөр хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, төсөвлөх, хэрэгжүүлэх үйл ажиллагааг удирдан зохион байгуулах, санхүүжилтийн эрх нээх, нэгдсэн бүртгэл хөтлөх, хэрэгжилтэд хяналт тавих, үнэлэх, тайлагнах, мэдээллийн сан бүрдүүлэх зэрэг үйл ажиллагааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасныг баримтлан төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын нэгдсэн цахим системээр хэрэгжүүлнэ.

25^{1.5}. Гадаадын тусламжийн хөрөнгөөр төсөл, арга хэмжээг хэрэгжүүлж байгаа төсөл хэрэгжүүлэх нэгжийн ажилтан, бусад зөвлөхтэй байгуулах гэрээ нь Иргэний хуулийн хөлсөөр ажиллах гэрээ байна.

25^{1.6}. Энэ хуульд зааснаас бусад гадаадын тусламж авах, гэрээ байгуулах, тусламжаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, удирдлага, зохицуулалтаар хангах, тусламжийн хөрөнгийг зөв зохистой зарцуулах, төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэх, тусламжийн өмч, хөрөнгийг бүртгэх, хяналт тавих, тайлагнах, үнэлэх харилцааг энэ хуулийн 11.1.24-т заасан журмаар зохицуулна.”

7/27 дугаар зүйлийн 27.1.11 дэх заалт:

“27.1.11.төсвийн хөрөнгө оруулалтын төслийн тухайд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан зарчим, шаардлагыг хангасан байх.”

8/31 дүгээр зүйлийн 31.1.7 дахь заалт:

“31.1.7.төсвийн хөрөнгө оруулалтын төслийн саналыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар ирүүлсэн байх.”

9/57 дугаар зүйлийн 57.6 дахь хэсэг:

“57.6.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, тайлагнах, өмч, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд энэ хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг баримтална.”

10/60 дугаар зүйлийн 60.13 дахь хэсэг:

“60.13.Орон нутгийн хөгжлийн сангийн эх үүсвэрээр хөрөнгө оруулалтын төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэх, тайлагнах, өмч, хөрөнгийн удирдлагыг хэрэгжүүлэхэд энэ хууль болон Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг баримтална.”

11/67 дугаар зүйлийн 67.4 дэх хэсэг:

“67.4.Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын төслийг төлөвлөх, бэлтгэл ажиллагааг хангахад Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг баримтална.”

2 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 2 дугаар зүйлийн 2.1 дэх хэсгийн “Төсвийн тогтвортой байдлын тухай хууль,” гэсний дараа “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай,” гэж, мөн хуулийн 58 дугаар зүйлийн 58.2 дахь хэсгийн “улсын төсвөөс” гэсний өмнө “Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг баримтлан” гэж тус тус нэмсүгэй.

3 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн дараах зүйл, хэсэг, заалтыг доор дурдсанаар өөрчлөн найруулсугай:

1/4 дүгээр зүйлийн 4.1.24 дэх заалт:

“4.1.24.“төсвийн хөрөнгө оруулалт” гэж Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийн 4.1.23-т заасныг;”

2/12 дугаар зүйлийн 12.1.23 дахь заалт:

“12.1.23.төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын үйл ажиллагааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар хэрэгжүүлэх.”

3/14 дүгээр зүйлийн 14.2.4 дэх заалт:

“14.2.4.төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын талаарх чиг үүргийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар хэрэгжүүлэх;”

4/14 дүгээр зүйлийн 14.2.8 дахь заалт:

“14.2.8.төсвийн хөрөнгө оруулалтын төслийн хэрэгжилтийг хянах, тайлагнах чиг үүргийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар хэрэгжүүлэх;”

5/17 дугаар зүйлийн 17.1 дэх хэсэг:

“17.1.Хөгжлийн түнш, олон улсын байгууллага, хандивлагч орноос Засгийн газрын шугамаар Монгол Улсад хөгжлийн санхүүжилтийн хүрээнд олгож байгаа гадаадын зээл, тусламжаар хэрэгжүүлэх төслийн нэгж нь төсвийн байгууллага байх бөгөөд холбогдох салбарын төсвийн ерөнхийлөн захирагчийн дэргэд нэгдсэн төсөл хэрэгжүүлэх нэгжийн хэлбэрээр төслийн үйл ажиллагааг хэрэгжүүлнэ.”

6/27 дугаар зүйлийн 27.6 дахь хэсэг:

“27.6.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, бэлтгэл ажил, санхүүжилт, хэрэгжилт, хөрөнгийн удирдлагыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.”

7/29 дүгээр зүйл:

“29 дүгээр зүйл.Хөрөнгө оруулалтын төсөвлөлт

29.1.Төсвийн хөрөнгө оруулалтын төслийн төлөвлөлт, үнэлгээ, төсөвлөлт, тавигдах шаардлага болон холбогдох бусад асуудлыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд зааснаар зохицуулна.”

8/32 дугаар зүйлийн 32.2.6 дахь заалт:

“32.2.6.хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээний жагсаалтыг хавсралтаар /нэр, байршил, хүчин чадал, төслийн код, хэрэгжүүлэх хугацаа, анхны, сүүлийн болон тухайн жилийн төсөвт өртөг, санхүүжүүлэх эх үүсвэр, тухайн төсвийн жилийн санхүүжилтийн дүн/,”

4 дүгээр зүйл.Төсвийн тухай хуулийн 25¹ дүгээр зүйлийн дугаарыг “25² дугаар зүйл” гэж, 33 дугаар зүйлийн 33.2.6 дахь заалтын “төсөвт өртөг, анхны төсөвт өртөг,” гэснийг “анхны, сүүлийн болон тухайн жилийн төсөвт өртөг,” гэж тус тус өөрчилсүгэй.

5 дугаар зүйл.Төсвийн тухай хуулийн 10 дугаар зүйлийн 10.1.13, 10.1.14, 10.1.15 дахь заалт, мөн зүйлийн 10.5 дахь хэсэг, 11 дүгээр зүйлийн 11.1.23 дахь заалт, 25 дугаар зүйлийн 25.11, 25.13 дахь хэсэг, 27¹ дүгээр зүйл, 28 дугаар зүйлийн 28.11 дэх хэсэг, 29¹ дүгээр зүйл, 33 дугаар зүйлийн 33.2.8 дахь заалт тус бүрийг тус тус хүчингүй болсонд тооцугай.

6 дугаар зүйл.Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ХОТ БАЙГУУЛАЛТЫН ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ, ӨӨРЧЛӨЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Хот байгуулалтын тухай хуульд доор дурдсан агуулгатай хэсэг, заалт тус бүрийг нэмсүгэй:

1/4 дүгээр зүйлийн 4.1.4 дэх заалт:

“4.1.4.хөрөнгийн эх үүсвэр, санхүүжилтийг тооцсон, санхүү, төсвийн бодлого, төлөвлөлттэй уялдсан байх.”

2/11 дүгээр зүйлийн 11.7 дахь хэсэг:

“11.7.Хот байгуулалт, хот төлөвлөлтийн баримт бичгийг боловсруулах хүрээнд төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэх тохиолдолд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг баримтална.”

3/21 дүгээр зүйлийн 21.2 дахь хэсэг:

“21.2.Хот байгуулалтын үйл ажиллагааг хэрэгжүүлэхэд шаардлагатай төсвийн хөрөнгө оруулалтын төсөл төлөвлөх, хэрэгжүүлэх, санхүүжүүлэхэд Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг удирдлага болгоно.”

2 дугаар зүйл. Хот байгуулалтын тухай хуулийн 12 дугаар зүйлийн 12.9 дэх хэсгийн “асуудлыг” гэснийг “асуудал болон хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг” гэж өөрчилсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хуульд доор дурдсан агуулгатай дараах зүйл, хэсэг нэмсүгэй:

1/20.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэг:

“3.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр чанар муутай барилга байгууламж барьсан, бариулсан, их засвар хийсэн, хийлгэсэн, чанар муутай тоног төхөөрөмж хүлээлгэн өгсөн, хүлээн авсан, барилга байгууламж, их засвар, тоног төхөөрөмжийг ашиглалтад оруулсан, эсхүл энэ талаар шийдвэр гаргасны улмаас хүний эрүүл мэндэд хүнд хохирол учирсан, эд хөрөнгөд их хэмжээний хохирол учирсан бол арван мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2/20.13 дугаар зүйлийн 4 дэх хэсэг:

“4.Энэ хуулийн 20.13 дугаар зүйлийн 3 дахь хэсэгт заасан гэмт хэргийн улмаас хүний амь нас хохирсон, ноцтой хохирол, хор уршиг учирсан бол хорин мянган нэгжээс дөчин мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

3/22.14 дүгээр зүйл:

“22.14 дүгээр зүйл.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулалтын бусаар зарцуулах, муутгах, ашиглах боломжгүй болгох

1.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулалтын бусаар зарцуулах, төсөвт өртгийг үндэслэлгүй нэмэгдүүлснээс төсөвт их хэмжээний хохирол учирсан бол нийтийн албанд ажиллах эрхийг хоёр жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.

2.Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр бий болсон төрийн болон орон нутгийн өмчийн ашиглалт, сайжруулалт, хадгалалт, хамгаалалтыг зохих ёсоор хийгээгүйгээс чанар байдлыг хэвийн хэмжээнээс илүүгээр муутгасан, ашиглах боломжгүй болгосон, их засвар хийх шаардлагатай болсон, төсөвт их хэмжээний хохирол учирсан бол нийтийн албанд ажиллах эрхийг гурван жилээс таван жил хүртэл хугацаагаар хасаж хоёр мянга долоон зуун нэгжээс арван дөрвөн мянган нэгжтэй тэнцэх хэмжээний төгрөгөөр торгох, эсхүл зургаан сараас гурван жил

хүртэл хугацаагаар зорчих эрхийг хязгаарлах, эсхүл зургаан сараас гурван жил хүртэл хугацаагаар хорих ял шийтгэнэ.”

2 дугаар зүйл. Эрүүгийн хуулийн 22.8 дугаар зүйлийн 1 дэх хэсгийн 1.6 дахь заалтын “улсын төсвийн,” гэсний дараа “орон нутгийн төсөв, орон нутгийн хөгжлийн сан, гадаад зээл, тусламжийн,” гэж нэмсүгэй.

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРҮҮГИЙН ХЭРЭГ ХЯНАН ШИЙДВЭРЛЭХ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрүүгийн хэрэг хянан шийдвэрлэх тухай хуулийн 6.1 дүгээр зүйлийн 2.1 дэх заалтын “22.13/Хахууль авах” гэсний дараа “, 22.14/Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрийг зориулалтын бусаар зарцуулах, муутгах, ашиглах боломжгүй болгох” гэж нэмсүгэй.

2 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ЭРЧИМ ХҮЧНИЙ ТУХАЙ ХУУЛЬД НЭМЭЛТ ОРУУЛАХ ТУХАЙ

1 дүгээр зүйл. Эрчим хүчний тухай хуульд доор дурдсан агуулгатай дараах хэсэг тус бүрийг нэмсүгэй:

1/2 дугаар зүйлийн 2.6 дахь хэсэг:

“2.6. Эрчим хүчний салбарт төсвийн хөрөнгө оруулалтаар төсөл хэрэгжүүлэхтэй холбогдсон харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

2/6 дугаар зүйлийн 6.3 дахь хэсэг:

“6.3. Төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэрээр хэрэгжүүлэх эрчим хүчний салбарын төслийн төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын санг бүрдүүлэх, захиран зарцуулахтай холбоотой харилцааг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулиар зохицуулна.”

3 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ХУУЛЬ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛИЙГ ДАГАЖ МӨРДӨХ ЖУРМЫН ТУХАЙ

1 дүгээр зүйл. Энэ хуулийг дагаж мөрдөх өдрөөс өмнө тухайн жилийн төсвийн тухай хуулиар батлагдан төслийн гэрээ байгуулан хэрэгжиж эхэлсэн төслийн хэрэгжилт, санхүүжилт, хяналт, тайлагналт болон хөрөнгийн удирдлага, ашиглалт, түүний үр өгөөжийг тооцохтой холбоотой харилцааг уг хуулиар зохицуулна.

2 дугаар зүйл. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан журмыг хууль хүчин төгөлдөр болсноос хойш 24 сарын хугацаанд шинэчлэн боловсруулж, батлах ба ийнхүү батлагдах хүртэлх хугацаанд тухайн харилцааг хүчин төгөлдөр мөрдөгдөж буй дүрэм, журам, холбогдох баримт бичгээр зохицуулна.

3 дугаар зүйл. Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн эх үүсвэрийг бүрдүүлэх, шилжүүлэхтэй холбогдсон үйл ажиллагааг 2026 оны төсвийн жилээс эхлэн хэрэгжүүлнэ.

4 дүгээр зүйл. Төсвийн хөрөнгө оруулалтын мэдээллийн нэгдсэн санд хамаарах хуульд заасан холбогдох бүх мэдээллийг төсвийн төсвийн хөрөнгө оруулалтын эх үүсвэр тус бүрээр цахим системийн удирдлагад хамруулах ажлыг 2027 онд багтаан хэрэгжүүлнэ.

5 дугаар зүйл. Энэ хуулийг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль хүчин төгөлдөр болсон өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

ГАРЫН ҮСЭГ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРЛЫН ТОГТООЛ

2025 оны дугаар
сарын ... ны өдөр

Улаанбаатар
хот

ТӨСВИЙН ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН УДИРДЛАГЫН ТУХАЙ ХУУЛЬ БАТЛАГДСАНТАЙ ХОЛБОГДУУЛАН АВАХ АРГА ХЭМЖЭЭНИЙ ТУХАЙ

Монгол Улсын Их Хурлын чуулганы хуралдааны дэгийн тухай хуулийн 44 дүгээр зүйлийн 44.5 дахь хэсгийг үндэслэн Монгол Улсын Их Хурлаас ТОГТООХ нь:

1.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хууль батлагдсантай холбогдуулан дараах арга хэмжээг авч хэрэгжүүлэхийг Монгол Улсын Засгийн газар /Г.Занданшатар/-т даалгасугай:

1.1.төрийн захиргааны төв байгууллага, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга, бүх шатны төсвийн захирагч нарт Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуулийг сурталчлан таниулах, холбогдох сургалтуудыг зохион байгуулах;

1.2.хөндлөнгийн хяналт хийх, олон улсын байгууллагаас гаргасан жишиг гэрээг хэрэглэхтэй холбоотой арга зүйн дэмжлэг үзүүлэхийг холбогдох төсвийн ерөнхийлөн захирагч нарт;

1.3.хүчин төгөлдөр мөрдөгдөж буй төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагад хамаарах дүрэм, журам, холбогдох бусад эрх зүйн актуудыг Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд нийцүүлэн өөрчлөх, шинээр боловсруулах ажлыг зохион байгуулах;

1.4.Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын тухай хуульд заасан Төсвийн хөрөнгө оруулалтын удирдлагын сангийн эх үүсвэрийг холбогдох бусад Норм, нормативын сангаас шилжүүлэх, шинээр төвлөрүүлэх арга хэмжээг 2027 оны төсвийн жилээс эхлэн хэрэгжүүлэх;

1.5.дэд бүтцийн салбарт норм, нормативын сангийн харилцааг зохицуулж байгаа захиргааны хэм хэмжээний акт тус бүрийг уг хуультай уялдуулан 2027 оны 7 дугаар сард багтаан өөрчилж, шинэчлэх.

ГАРЫН ҮСЭГ